



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/759

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/ 29.1.5/а/, 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 6/02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2018 оны 12 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд БНХАУ-ын Фүшион хотод зохион байгуулагдах “Ширээний теннисний Ахмадын Азийн аварга шалгаруулах 12 дахь удаагийн тэмцээн”-ий 40-49 насны ангилалд оролцох “Эрдмийн сан” сургуулийн биеийн тамирын багш Чулуунбаатарын Нямаагийн замын зардалд 1000000 /Нэг сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Замын зардалд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг “Багш” дэд хөтөлбөрийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааны үр дүнг сурталчлах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /н.Бат-Амгалан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ